

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +18
Шөнө +7

УЛС ТӨР

НЭР ДЭВШИЖ БУЙ АН-ЫН 100 ОРЧИМ ТӨЛӨӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗЖЭЭ

II нүүрт

СПОРТ

ДЭЛХИЙН БӨХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ХУРЛААР МОНГОЛЫН АСУУДЛЫГ ЯРЬСАНГҮЙ

VIII нүүрт

Дугаарын **60** мөр
Дарга ерөнхийлөгчтэй байх сайхан юм аа

Хэн юу хэлэв

Э.ЛУУЛ

Өнгөрсөн долоо хоногт УИХ-ын ээлжит бус чуулган үргэлжилж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоолын төсөл, мөн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Мөн Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталж, зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлж, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь баталж, долоон хуулийн төслийг төсөл санаачлагчид нь буцаалаа.

Үүнээс гадна Засгийн газрын ээлжит хуралдаанаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, УИХ-д дахин өргөн барихаар шийдвэрлэсэн. Мөн орон нутгийн сонгуульд нэр дэвших хүмүүсээ намууд бүртгүүлсэн гээд олон үйл явдал өрнөсөн. Дашрамд дурьдахад, УИХ-ын



элжит бус чуулганыг өнөөдөр хаахаар боллоо. Өнөөдөр ээлжит бус чуулган сүүлийн хуралдаанаа хийж, төсөвт тодотгол оруулж, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлах юм. Тиймээс “Хэн юу хэлэв” булангаараа өнгөрсөн долоо хоногт өрнөсөн үйл явдлын талаар онцоллоо.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ТӨРИЙН БОДЛОГООС ЗУГТСАН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ТАТАХ ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

Н.БАТЗАЯА

“Дисковер Монголиа” уул уурхайн хөрөнгө оруулагчдын 14 дэх удаагийн олон улсын чуулга уулзалт өчигдөр Корпорейт Конвэйшн центрт эхэллээ. Чуулга уулзалтад оролцогчид Уул, уурхайн салбарын хөгжил, Монголын төрийн бодлого болон манай улсад хэрэгжиж буй олон улсын томоохон төслүүд зэрэг асуудлаар илтгэл тавьсан юм. Энэхүү уулзалт нь гадаадын хөрөнгө оруулагчдад Монголын уул уурхай, төрийн бодлого, эдийн засгийн талаар мэдээлэл хүргэх, хамтран ажиллах санал солилцох зорилготой. “Дисковер Монголиа” чуулганы үеэр гадаадын болон салбарын мэргэжилтнүүдтэй уулзаж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах болон уул уурхайн өнөөгийн байдал, түүнээс гарах арга замын талаарх байр суурийг сонслоо.

Төгсгөл нь IV нүүрт



ДОТОР НҮҮРТ

КҮНИЭДА ШИНГО: БИ ЯЛАГДАХ ДҮРГҮЙ

Х.НОРЖИН

Монголын ард түмний 80 шахам хувь нь арай хийж есдүгээр сарын 1-ний өдрийн ард гарсан. Их, дээд сургуульд элсэн суралцах хуваарь авсан хүү, охиныхоо сургалтын төлбөрийг төлөх гэж арга үйлээ барсан нэг хэсэг байхад, цэцэрлэг, сургуульд зэрэг зэрэг явах хүүхдүүдийнхээ хичээлийн бэлтгэлийг хангах гэж ээмэг бөгжөө барьцаат зээлийн газар тавиад ч мөнгө нь дутсаны улмаас ахлах ангид сурч байгаагийнх нь байгаагаар түр аргал гээд хойш тавин тэвдэж сандарсан хүмүүс дээр өгүүлсэн 80 хувьд багтана.

Төгсгөл нь III нүүрт

СЭТГЭЖ БУЙ БҮХЭНД ХҮРЧ ЧАДСАН 20 ЖИЛ

“Хэн сэтгэж байна түүнд зориулав” гэсэн биеэ тоосон ч гэмээр юм шиг уриатай сонин 20 жил уншигчдад хүрчээ. Нэг талаараа бодоход онгиородуу ч нөгөө талаараа сэтгэж буй гэдгээ харуулах гэсэн хүн бүр унших ёстой мэт маркетингийг илтгэсэн энэ уриа “Өнөөдөр” сонингийн толгойд заларсаар хэр удсаныг мэдэхгүй. Гэсэн ч сэтгэж буй бүхэнд хүрч “Монгол нь” группээр овоглосон “Өнөөдөр” сонин монголын өдөр тутмын сонинууд дундаа цоо шинэ өнгө төрх, стандартыг бий болгож чадсаныг манай салбарынхан дуу нэгтэй хүлээн зөвшөөрнө.

Мэдээ мэдээлэлийн хурдтай эрэн зуунд цаасан хэвлэл тогтож үлдэх тэмцэл хийсээр л. Өглөөний цайгаа уунгаа сонин гарчиглах хэн нэгний дүр зураг өдгөө ховордсон ч цаасан хэвлэл мэдээний хурдтай эргэлтэн дунд өөрийн дүрийг бүтээсээр л байх болно гэдэгт итгэдэг. “Монгол нь” группийнхэн болон “Өнөөдөр” сонин залгамж болсон үе үеийнхэнд тэнцвэртэй, үнэн, тасралтгүй бичсэн 20 жилийн ойн мэндийг хүргэе.

МОНГОЛЫН ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ХОЛБОО



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

МЭДЭЭЛЭЛ

С.Чинзориг: Хамтын тэтгэврийн хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх ёстой

УИХ-ын чуулганы лхагва гарагийн үдээс хойшхи хуралдаанаар хүчингүй болгосон Хамтын тэтгэврийн тухай хуулийг тойрсон маргаан мэтгэлцэн нийгмийн сүлжээнд нэлээд олон хүнийг хамраад байна. С.Эрдэнэ нарын гишүүдийн өргөн барьж өнгөрсөн оны арванхоёрдугаар сард батлуулсан уг хуулийг хүчингүй болгох шийдвэрийг улстөрчид өөр өөрийн өнцгөөр тайлбарлаж буй юм. Хуулийн автор хэмээн өөрийгөө өргөмжилсөн УИХ-ын гишүүн С.Эрдэнэ тэтгэвэр авч байгаа 300 гаруй мянган ахмадын эрх зүйг дордууллаа, нэг үгээр ахмадуудын хувьд хар өдөр боллоо хэмээн сүргижнэсэн ч үүнийх нь эсрэг Засгийн газар илүү үнэмшилтэйгээр тайлбар хийж чадаагүй. Сангийн сайд, Ерөнхий сайд гээд Засгийн газрын гишүүд нь хүмүүсийн

сүсэг бишрэлтэй холбон үнэмшихэд ч бэрх шалтгааныг тоочсон нь олны дургүйцлийг хүргээд байгаа.

Харин УИХ-ын гишүүн С.Чинзориг "Хууль хүчингүй болсноор тэтгэвэр авч буй 300 мянган ахмадын эрхийг хасч байгаа юм биш. Хамтын тэтгэврийн тухай энэ хуулийн хэрэгжилт дээр цаг хугацааны хязгаар тавьснаар 7000 гаруйхан хүнд л хамаатай болж байгаа. Гэтэл манайд хань ижлээ алдсан 77 мянган ахмад байгаа учраас уг хуулийг буцааж хамтын тэтгэвэр авбал зохих бүх хүнийг хамруулахаар болгох ёстой юм" гэсэн нэмэлт тайлбар хийсэн. Нийгмийн хамгааллын салбараар мэргэшсэн түшээгийн хувьд түүний энэ тайлбар хууль хүчингүй болж буй үндэслэлийг ойлгохгүй бүхмидэж байсан олон хүний санааг амраав.

“Өнөөдөр” сонин хамт олонд 20 жилийн ойн баярын мэнд хүргэе

Тэртээ 1996 оны есдүгээр сард “Өнөөдөр” хэмээх их айл үүдээ нээснээс хойш 20 жилийг ардаа орхижээ. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт сэтгүүлч Ц.Балдорж агсны үүсгэн байгуулсан Монголын өдөр тутмын анхдагч чөлөөт хэвлэл “Өнөөдөр” сонин өдгөө эрийн цээнд хүрч, өөрийн өнгө төрх, нийтлэлийн бодлогоороо эрс ялгарч байгаа билээ. Монгол Улсад ардчилсан чөлөөт сэтгүүл зүй үүсч хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан, хараат бус дөрөв дэх засаглалыг хөгжүүлэхэд түүчээ болж яваа “Өнөөдөр” сонин, “Монгол нь” группийн үе үеийн удирдлага, сэтгүүлч, сурвалжлагч нарт 20 жилийн ойн баярын мэнд хүргэж, ажлын амжилт хүсэн ерөөе. Та бүхний үг нь мэргэн, үзэг нь хурц байх болтугай.

“Монголын мэдээ” сонин хамт олон

ХААН банк			Худалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2215.00	2235.00	ФУНТ	2909.00	3008.00	АМ.ДОЛЛАР	2215.00	2235.00
ЕВРО	2456.00	2542.00	РУБЛЬ	33.20	36.10	ЕВРО	2475.00	2545.00
ИЕН	21.54	22.17	ЮАНЬ	331.30	335.80	ИЕН	21.60	22.28
						ФУНТ	2939.00	3020.00
						РУБЛЬ	33.56	36.54
						ЮАНЬ	331.00	336.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Зам, тээврийн салбарт евро стандарт нэвтрүүлнэ

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл өчигдөр Бүгд Найрамдах Чех Улсын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Олдржих Заычек тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзлаа. Тэрбээр Монгол улсын автотээврийн зохицуулалтын үйл ажиллагааг БНЧУ-ын арга туршлагыг үндэслэн сайжруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг нэмэгдүүлэх Евро стандартын төслүүдийн талаар санал солилцсон юм. Уулзалтын үеэр Элчин сайдын яамны төлөөлөгчид Автотээврийн үндэсний төвийн удирдлагуудтай уулзаж, БНЧУ-д хийсэн ажлын айлчлалын үр дүнг сайшааж, цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэрэгжүүлэх гурван төслийг амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэж буйгаа илэрхийллээ. Дэд сайд Б.Цогтгэрэл “Монгол Улсад Евро стандартад нийцсэн хяналтын пост байгуулах, техникийн хяналтын үзлэгийн багаж, тоног төхөөрөмжийн явуулын лаборатори байгуулах зэрэг чухал төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зам, тээврийн салбарыг шинэ шатанд гаргах ажилд нягт хамтран ажиллана” гэв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

НЭР ДЭВШИЖ БУЙ АН-ЫН 100 ОРЧИМ ТӨЛӨӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗЖЭЭ

Ж.ОТГОН

АН-аас орон нутгийн болоод УИХ-ын сонгуультай холбоотой асуудлаар мэдээлэл хийлээ. Мэдээлэлд АН-ын хяналтын ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Б.Батхуяг, АН-ын намын байгуулалтын газрын дарга Л.Уртнасан, Багахангай дүүргийн АН-ын гишүүн Б.Анхныбаяр нар оролцоо. 2016 оны орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчдийн нэр дэвшигчдийг бүртгэх үйл ажиллагаа хуулийн хугацаанд албан ёсоор хэрэгжээд дууссан. Тэгвэл энэ хугацаанд орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй АН-ын гишүүдийг орон нутгийн сонгуулийн хороо болон сумын сонгуулийн салбар хороод бүртгэхээс татгалзсан байна. Энэ нь иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхийг зөрчиж байгаа гэдгийг АН-ын гишүүд онцлолоо. Энэ талаар АН-ын хяналтын ерөнхий хорооны нарийн бичгийн

дарга Б.Батхуяг “21 аймаг есөн дүүргийн хэмжээнд явагдаж байгаа сонгуулийн үйл ажиллагаа хууль зөрчсөн олон үйлдэл гарлаа. Улсын хэмжээнд орон нутгийн сонгуульд 14 мянган 300 орчим нэр дэвшигч бүртгэгдсэн. Гэтэл АН-ын 100 орчим нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан мэдээлэл нам дээр ирээд байна. Тиймээс бид тухайн аймгуудын сонгуулийн хорооноос нь мэдээлүүдийг нь авлаа. Энэ нь улс төрийн нэг хүчний үйл ажиллагааг дэмжсэн явдал гэж харж байгаа. Учир нь манай намаас 100 гаруй хүнийг бүртгэхээс татгалзсан. Гэтэл эрх баригч намын нэр дэвшиж буй төлөөлөгчдийг бүртгэхээс татгалзсан нэг ч хүний тогтоол гараагүй байна. Төрийн сонгуулийг удирдан зохион байгуулж явдаг төрийн албан хаагчдын энэ мэт үйлдэл үнэхээр хэрээс хэтэрсэн байна. Тухайлбал, нэр дэвшигчдийн гарын үсгийн хэв буруу, албаар бичиг баримтыг нь дугаах зэрэг

үл ялх зүйлээр шалтгаалсан, хууль зүйн үндэслэлгүй, улс төрийн нэг хүчний талыг барьсан шийдвэрүүдийг гаргаж байна” гэлээ. Бүртгэгчдийн нэр дэвшигчдийн тухайд Архангай аймгийн Өлзийт суманд АН-аас нэр дэвшиж буй 21, Өмнөговь аймгийн Ханхонгор сум 21 нэр дэвшигчдийг сумаар нь хассан. Мөн Улаанбаатар хотын Багахангай дүүрэг 17 нэр дэвшигчийг бүтгэж бүртгээгүй. Түүнчлэн Өгий нуур, Жаргалант сумаас болон Дархан-Уул аймгаас нэг, Баянхонгор аймгийн Шинэ жинст сум хоёр, Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хоёр нэр дэвшигчийг хассан гээд нийтдээ 100 орчим нэр дэвшигчийг хассан байна. Тэгвэл энэхүү үйлдлийг АН-ын зүгээс иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийг ноцтой зөрчиж буй үйлдэл хэмээн үзэж байгаа аж. АН-ын хяналтын ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Б.Батхуяг “Энэ удаагийн орон нутгийн сонгууль нэг улс төрийн хүчин оролцож байгаа

юм шиг битгий хандаач. Улс төрийн соёлтой байгаач. Орон нутгийн сонгуульд оролцож байгаа улс төрийн хүчүүдийг үйл ажиллагааг хэвийн явуулж, хуульд заасан эрхийг хангаж, Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхийг дээдэлэн ажиллахыг эрх баригч намаас шаардаж байна” гэв. Харин АН-ын намын байгуулалтын газрын дарга Л.Уртнасан “Сумын болон дүүргийн сонгуулийн хороодоос гарсан тогтоолууд, нэр дэвшигчдийг дүүрэг, сумаар нь хассан үйлдэл нь нэг цэг байхгүй, нэг хүний гарын үсэг байхгүй гэх шалтгаатай. Түүчлэн байсан тогтоолыг өөрсдөө авч устгагчиад тогтоол байхгүй байна гэдэг шалтга хэлэх жишээтэй. Ямар ч улс төрийн нам

төрийн сонгуулийг хуулийн дагуу явуулах байх гэж итгэж, найдаж байгаа гэдгийг энэ үеэр дуулгаж байлаа.

Багахангай дүүргийн АН-ын бүх нэр дэвшигчдийг хассан

Ийнхүү сонгуулийн хороод хууль зөрчиж байгаа мэдээлэл одор бүр ирж байгаа гэнэ. Тухайлбал, дүүргийн АН-ын бүх нэр дэвшигчээ хасуулчихаад байгаа талаар Багахангай дүүргийн АН-ын гишүүн Б.Анхныбаяр “Манай Багахангай дүүрэг маань нийт 3500 оршин суугчидтай. 17 төлөгч байдаг. Гэтэл 17 төлөөлөгчөөс МАН-аас 17, АН-аас 17 нар дэвшигч дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлэхээр бичиг баримтаа өгсөн. Гэтэл манай АН-ын нийт 17 нэр дэвшигчийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хассан. Багахангай дүүргийн сонгуулийн тогтоолоор бүртгэж авахаас татгалзсан шийдвэр гаргасан. Тиймээс бид яагаад татгалзсан тогтоол гаргасан гэдгийг тодруулахад, хоёр үндэслэлээр гэж тайлбарласан. Нэгдүгээрт, 17 төлөөлөгчийн нэг хүн нь өргөдөл зэрэг гарын үсэг зураагүй гэдэг шалтгаанаар нийт 17 төлөөлөгчийг бүртгэхээс татгалзсан. Хоёрдугаарт, манай дүүргийн намын хурлын тогтоолыг хүлээж аваагүй гэдэг үндэслэл хэлсэн. Гэтэл бид бичиг баримтаа өгөхдөө намын дүүргийн тогтоолыг хүлээлгэн өгсөн. Харин дүүргийн сонгуулийн хороо энэ тогтоол байхгүй байна гэж шалтгаанаар дүүргийн АН-ын гийг 17 төлөөлөгчийг бүртгэхээс татгалзсан асуудал үүсээд байна” хэмээсэн юм.

MINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
 18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТООГО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТӨГТОХ 88006842**

Тоймч: **Х.БАТСАЙХАН 88094039**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТӨГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛИАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
 Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 210, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцияд эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн ажлын явцыг хэлэлцлээ

Монгол Улсын Засгийн газар Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын гэрээгээр хамтран хэрэгжүүлж байгаа “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт “Хотын засаглалыг сайжруулах” төслийг тус тус хэрэгжүүлж эхлээд

жил гаруй хугацаа өнгөрч байна. ТСБД төсөл хэрэгжих хугацаанд Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор батлуулсан. Одоо бид энэхүү бодлогын баримт бичигт нийцүүлэн төв орон нутгийн түвшин дэх чиг үүргийг оновчтой дахин хувиарлах аргачлалыг боловсруулан батлуулахаар төвлөхөн ажиллаж

байна. Хэлэлцүүлгийн үеэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн “Засгийн газрын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн Засаглалын бодлого гэсэн хэсэгт төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгаж, цомхон бүтэцтэй байлгах. Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх

бодлого баримтлах, эрх зүйн орчныг цогцдоор бүрдүүлэх, Монгол Улсын засаг захиргаа, түүний удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох гэх мэтээр төвлөрлийг сааруулах бодлогыг цаашид шат дараатай хэрэгжүүлэх нөхцөл, суурийг тусгаж өгсөнөөрөө дээр бодлогын баримт бичгийг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болж байна” хэмээн хэлсэн.

АЙЛЧЛАЛ

КАНАД, МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Ж.МЯГМАР

УИХ-ын дарга М.Энхболдын урилгаар Канад Улсын парламентын Нийтийн танхимын дарга Жофф Рэган тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийхээр хүрэлцэн ирээд байгаа. Канад Улсын парламентын Нийтийн танхимын дарга Жофф Рэган айлчлалынхаа хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхаж, УИХ-ын дарга М.Энхболдтой албан ёсны уулзалт хэлэлцээ хийлээ. Энэ үеэр УИХ-ын дарга М.Энхболд, Канад Улсын парламентын Нийтийн танхимын дарга ноён Жофф Рэганыг албан ёсны айлчлал хийж буйд талархал илэрхийлээд “УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд МАН үнэмлэхүй ялалт байгуулсан бөгөөд шинэ парламентын анхны хүндэт зочид нь Та бүхэн болж байгааг дуулгахад таатай байна” гэв. Энэ удаагийн УИХ-д хамгийн олон буюу 13 эмэгтэй гишүүн сонгогдсон, үүнд Канад Улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн УИХ-ын сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих төсөл тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн гэдэгт итгэлтэй байна гэлээ. Ноён Жофф Рэганы энэхүү айлчлал нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад онцгой ач холбогдолтой хэмээн үзэж байгаагаа УИХ-ын дарга тэмдэглэн хэллээ. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл хүнд байгаа хэдий ч иргэдэд хүндэрл учруулахгүй байх талаар Монгол Улсын төр засгаас онцгой анхааран ажиллаж байгааг тэрбээр дурдаад “Эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулахад хөрөнгө оруулалт чухал нөлөөтэй хэмээн үзэж, бид хөрш орнууд болон бусад улсын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамгаалах талаар онцгой анхаарал хандуулан ажиллаж болно. Монгол



Улсын хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагчдын аюулгүй байдлыг хангах нь монгол төрийн үүрэг юм. Энэ чиглэлээр Засгийн газар тодорхой арга хэмжээнүүд авч эхэлж байгаа” хэмээлээ. Түүнчлэн айлчлалын хүрээнд “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурж байгаа нь ихээхэн дэмжлэг болно хэмээн үзэж байна гэв. Үүний дараа Канад Улсын парламентын Нийтийн танхимын дарга Жофф Рэган Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил Канад Улсын парламентын Нийтийн танхимын даргад бараалхалаа. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат ноён Жофф Рэгантай уулзахадаа

Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх зорилгуудын хүрээнд эдийн засгаа сэргээж, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад анхаарч ажиллаж байгаагаа хэллээ. Монгол, Канадын харилцаа, хамтын ажиллагааг жилээс жилд өргөжиж бүхий л салбарыг хамарч байна. Үүний дотор эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбар тэргүүлэх байр суурьтай байгаа нь хоёр орны харилцаа улам бүр гүнзгийрэн хөгжихийн үндэс юм. Канад нь Монгол Улсын гуравдагч хөрш, Хойд Америк дахь чухал түнш орон. Тиймээс бид харилцаагаа иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүргэж ажиллах зорилготой байгаагаа Ерөнхий сайд онцлолоо. Өчигдөр байгуулагдсан “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” нь Канадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын үүд хаалга үргэлж нээлттэй байхын илрэл болно гэдгийг хэлээд Монголын уул уурхайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ Канад улс тэргүүлж байгаа.

Канад Улс нь Монголд хөгжлийн албан ёсны тусламж үзүүлж байгаад Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс талархлаа илэрхийлж, тусламжийг үр өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, урт хугацаанд тогтвортой ажиллах чадавхийг бий болгоход анхаарна гэлээ. Айлчлалын хүрээнд Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Э.Жэйгэр нар “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Уг хэлэлцээр нь Монгол Улсад Канадын хөрөнгө оруулалтыг татаж, улмаар Монголын ард түмэнд хүртээмжтэй, эдийн засгийн хөгжил, цэцэглэлд хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байгаагаа талууд нотлов. Канадын Парламентын даргын энэ удаагийн айлчлал нь хоёр орны хууль тогтоох байгууллага хоорондын төдийгүй хоёр талын дээд, өндөр хэмжээний айлчлалын давтамжийг хадагалахад чухал ач холбогдолтой юм. Канад Улсын парламентын Нийтийн танхимын дарга Жофф Рэган Монгол Улсад албан ёсны айлчлал хийхийн зэрэгцээ Канад сангаас хэрэгжүүлж буй төсөлтийг танилцахаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улаанчулуут дахь “Нарны хүүхдүүд” цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах төлөвлөгөөтэй байгаа юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Хэн юу хэлэв



Харалган бодлыг нь хүлээн зөвшөөрөх хэмжээний 65 суудал байгаа нь хэнийг ч хаан болгох үүд хаалгыг нээнэ

Х.Т.Дэмүржсин:

Дугаарын 60 мөр

Дарга ерөнхийлөгчтэй байх сайхан юм аа

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Энэ бол дундаж болон дунджаас доош орлоготой иргэдийн амьдралын нэгээхэн дүр зураг. Шинэ оюутан, шинээр цэцэрлэг, сургуульд элсэн суралцах хүүхэдтэй айл бүр их сандарсан байж ч мэднэ. Ядах нь ээ, цэцэрлэгийн хүрэлцээ муу учраас хандив хийгээд хахуулын 500 мянган төгрөгийг нэмж олох хэрэг гараа биз. Ард түмэн ингэж хойд хормойгоороо урд хормойгоо нөхөн үүр цайлгаж байхад хурдан морь уядаг нөхдийн үр сад болох залуучууд цахим ертөнцөд “Морин спорт, залуу уяачдын холбооны анхдугаар чуулган” ирэх сарын 7-8-ны өдрүүдэд болох талаар зар тавьж, сүржигнэж байх ч гэж дээ. Ингэж хэлэхээр монгол морины удам угшлыг сайжруулах, даншиг наадмыг өргөн хүрээнд нарийн дэг жаягтайгаар зохион байгуулах, ирлийн мөрийг цаашид уралдуулах эсэх, морины жүжээний стандартыг тогтоох гэхчилэн цаашид дэлхийн жишигт нийцсэн морин тойруулгатай болж, түүгээр дамжуулан бооцот уралдааныг зохион байгуулж олсон ашгаараа уяачдад олгодог бай шагналын хэмжээг нэмэгдүүлэх, морь нь түрүүлсэн уяачийн хөдөлмөрийг үзүүр түрүүнд үлдсэн бөхтэй адилтган гурваас таван ороо байраар шагнадаг болох, хурдан морины хүч чадал, дархлаажуулалтад анхаарч хамгийн өндөр үнэтэй сайн эм бэлдмэлийг оруулж ирэх гээд ярих зүйл их байна.

Түүнчлэн УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдөх уяачдын тоог нэмэгдүүлэх цаашид Морин спорт уяачдын холбооноос намын дарга, сайд, дэд сайд нар төрсөн, эдүгээ Монгол Улсын Ерөнхийлөгч энэ холбооноос төрөх ёстойг бүтгээрээ анхаарч, сонгуулийн хандивыг эртхэн цуглуулах гэхчилэн аминд тулсан, шийдвэрлэвэл зохиох асуудлууд зөндөө байхад хэвлэлийнхэн юу гэж хуцаад байгаа юм гэх байх л даа. Хэдийгээр хэн юу зохион байгуулах нь энэ цаг үед нээлттэй хэдий ч эдийн засаг хямарч тэвдэж байхад биений амраар мөнгө олдог уяачид, бөхчүүд нийгмийн сайн сайхны төлөө өвлэлдэн өгдөгж, нутаг усныхаа нэн ядуу орхийн хүүхдүүдэд сайхан сэтгэлийн тусыг хүргэдэгсэн бол ард түмэн тэднийг ингэтлээ үзэн ядахгүй байсан байж мэднэ. Тэд дүн өвлийн хүйтнээр ч адуус хүүхэд хоёрыг зовоон морио уралдуулан түүгээрээ сэтгэлийн жаргал эдлэн, хурдлах шинжтэй унага, даага, шүдлэн, удам сайтай гүүг үнэ цохин наймаалцаад зогсохгүй эдэлж хэрэглэж байгаа эмээл, хазаар, унаж яваа машин, өмсгөл зүүсгэлээрээ өрсөлдөн сүйдийг хийдэг юм гэнэ дээ. Ингэж тансаглахынхаа оронд ядах нь ээ, хурдан мориныхоо хүүхдийн боловсролд анхаарах талаар хуралдаасай билээ. Өнөөдөр улсын хэмжээнд зургаан мянга гаруй унаач хүүхэд бий гэсэн статистик үзүүлэлт байх юм.

Энэ бол зөвхөн том том уяачдын мөрийг унаж уралдуулдаг хүүхдийн тоо. Тэдгээр хүүхдийн 10 хүрэхгүй хувь нь сургуульд явсан болдог. Үлдсэн нь хүүхэд насаа морины жүчээ, хор найруулж наймаа панз үсэргэсэн мөнгөний уяачийн хатавчинд өнгөрүүлж буй. Нэртэй зүстэй гэгддэг бусдаар морио уяулж шагнал, нэр алдрыг нь ороо хүртдэг уяачдын тухайд өөрийнхөө хүүхдийг сургуулиас нь гаргаж мориноос өөрийг мэдэхгүй болтол нь айлын хатавчинд байлгасан нь юу л бол. Үнэндээ унаач хүүхдүүд гэдэг нь нэн ядуу айлын хөвгүүд голдуу байдаг нь нууц биш. Архичин эцэг, эхээсээ дайжин хоногийн хоолтой айлын хаяа бараадсан нь цөөнгүй. Бодит амьдрал ийм л байна. Тэгээд ч өмнө нь уяачид чуулж байна энэ тэр гэж дууддаж байгаагүй санагдана. Эсвэл эдийн засаг гайгүй, иргэдийн бухимдал дээд цэгтээ хүрээгүй байсан тул тэдний хуралдахыг анзаардаггүй байсан юм болов уу. Морин спорт уяачдын холбоо гэнэт л өнгөрсөн зунаас амь орж гэнэ. Холбооны ерөнхийлөгч нь намын дарга, УИХ-ын дарга байх гэж ч юм уу. Мөнгөн бороо зүсэрч, түүнийгээ үрж барахгүй болохоор чуулган нэрээр наргиж цэнгэж, албан тушаалын наймаа хийлцээд л. Тиймээс эгэл ардууд уяачидтай барыцаж, хамгийн том Ерөнхийлөгчийн нь нэн ядуу, орлого багатай иргэдийн холбоо байгуулж, тэргүүнээрээ сонгоё. Яагаад болохгүй гэж. Бидэнд уяачдаас илүү зовлон байна.

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Б.Пүрэвдорж: Өрийн босгыг 88 хувь болгох гэж байна

/УИХ-ын гишүүн/

Сангийн яамнаас 2016 оны төсвийн тодотголыг өргөн барьсан. Тэгвэл Төсвийн тодотголтой танилцсан АН-ын гишүүд дэмжихгүй гэсэн байр суурьтай байгаа. Тэд зүгээр л дэмжихгүйдээ биш, дэмжиж болохгүй олон асуудал багтсан учраас эсрэг кноп дарж буйгаа илэрхийлсэн. Энэ талаар АН-ын гишүүн, УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “АН-ын бүлэг санал нийлэхгүй байгаа шалтгаан нь төсвийн тодотгол боловсруулахдаа нийгмийг хоёр хэсэгт хувааж нэг хэсэг нь баян, нөгөө нь ядуу байх бодлого оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл, дундаж давхаргыг байхгүй болгох бодлого оруулж ирсэн. Гэтэл нийгмийг авч явдаг, урагш хөтөлдөг хэсэг нь дундаж давхаргын хүмүүс байдаг. Тэднийг дэмжиж байж илүү амжилтанд хүрнэ. Харамсалтай нь, та нар ядуу байх ёстой гэдэг бодлогоор төсвийн тодотголыг боловсруулсан байгаа юм. Хоёрдугаарт, төсвийн тодотголд 430 тэрбум төгрөгөөр зардал нэмэгдсэн. Орлого олох гэж ажиллаагүй. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх бодлого огт тусгагдаагүй. Дундаж давхаргынхан бол хувийн бизнестэй, тогтсон орлоготой, нэлээд хэдэн хүн ажлын байраар хангадаг. АН засаг барих хугацаанд жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авч байсан. Гэтэл өнөөдөр татвараар боож, хаах бодлого барих гээд байна. Үүнээс л хоёр намын хөгжилд хандах хандлага ямар их ялгаатай байгааг харж болно. Мөн тэтгэвэртэй холбоотой багц асуудал ард иргэдэд сөрөг нөлөөтэй. Төрийн алба баталгаатай байх үндэс нь цалин, тэтгэвэр, тэтгэмж юм. Төрийн албанд тогтвортой ажилласан хүмүүс 12-36 сар хүртэл тэтгэмж авдаг. Үүнийг байхгүй болгох гээд байна. Насаараа багш хийсэн хүн тэтгэвэрт гарахдаа 36 сарын тэтгэмж аваад, шаардлагатай зүйлдээ зарцуулахаар төлөвлөж байж болно. Эдгээр хүмүүсийн бодол дээр ус цацаж байна гэсэн үг л дээ. Хоёрдугаарт, хамтын тэтгэврийг болуулж, тэтгэврийн насыг уртасгаж байна. Өнгөрсөн дөрвөн жилд хэрэгжүүлсэн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн бодлоготой холбоотой эерэг зүйлсийг цуцалж байгаа тул төсвийн тодотголыг дэмжихгүй. Энэ тодотголыг Засгийн газар буцаан татаж авах ёстой” гэж, байр сууриа илэрхийлжээ.

Д.Хаянхярваа: 2016, 2017, 2018 он хүнд жилүүд байж магадгүй

/УИХ-ын гишүүн/

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг УИХ-ын чуулганаар энэ өдрүүдэд хэлэлцэж байна. Ж.Эрдэнэбатын засаг энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд 26.9 их наяд төгрөг шаардлагатай байгааг хэлсэн. Засгийн газрын хөтөлбөр Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, Нийгмийн бодлого, Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого, Засаглалын бодлого гэсэн таван үндсэн бүлэг, 381 заалтаас бүрдэж буй. Тэгвэл УИХ дахь сөрөг хүчнийхэн болоод МАН-ын бүлгийн зарим гишүүн сонгуульд өгсөн амлалтаасаа ухарч байгааг шүүмжилж байгаа.

Энэ талаар УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа чуулганы хуралдаан дээр байр сууриа илэрхийлсэн юм. Тэрбээр “Намын мөрийн хөтөлбөрт тусгасан бүх саналыг бүрэн утгаар нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураахад байнгын хороон дээр унасан. Та нар “Монгол хүн 2020” гэдэг мөрийн хөтөлбөр барьж орж ирээд 45 хамгийн чухал заалтыг хасаад явж байсан шүүдээ. Мөрийн хөтөлбөр дотор бид харин ч бүгдийг нь багтаасан. Тэгж яривал мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв чинь улайчихаад байна. Та нар сонгуулийн өмнө зургаа, долдугаар сард нэг их наяд төгрөг юунд зарцуулсан нь мэдэгдэхгүй авчихсан байсан. Төсвийн алдагдал 4.4 их наяд төгрөг. Бид харин үүнийг сайжруулахаар явж байна. 2016, 2017, 2018 он хүнд жилүүд байж магадгүй. Бид эхлээд унаж доройтсон эдийн засгаа сэргээхээр байна. Та ингэж хоосон улс төр хийж болохгүй. Ард түмэн таныг МАН-ын мөрийн хөтөлбөрийг шүүмжилж байна гэж харах байх. Бүгдээрээ хоосон улс төрөө орхиё” хэмээсэн юм.

Л.Энх-Амгалан: Өөриймсөг мөртлөө улс оронд төрийн ухаан дутаад байгааг л хэлчихсэн

/УИХ-ын гишүүн/

УИХ-ын баасан гарагийн чуулганы хуралдаанаар энэ оны төсвийн тодотголын хуулийн төслийг хэлэлцэх үеэр УИХ гишүүн С.Жавхлан “Эдийн засаг гэдэг эд юмаа засаад аваад явахыг хэлдэг. Тухайн үед 6000 зүйлийг өөрсдөө хийдэг байж. Уг нь чинээлэг хүн гэдэг чин элэгтэй хүнийг хэлдэг. Чин элэгтэй хүн хэзээ ч түмэн олноосоо юмаа харамладаггүй, аминчхан үзэл байдаггүй хүмүүсийн хэлдэг. Тиймээс том том эмнэлэг, цэцэрлэг шиг байшинтай хүмүүс чин элэг гаргаж хүүхдэд цэцэрлэг

гаргаж өгөх хэрэгтэй. Өөрийн толгой дээрх бухлыг харахгүй байж хүний толгой дээрх өвсийг хараад байх юм. Авдраа уудал гэдэг түмэн олондоо хандахыг хэлнэ. Том том байшингуудаа болнод гэрээ бариад амьдарцгаа гэж уриалъя. Би үлгэрлэхгүй бол үлгээд хэрэггүй гэдэг үздэг. Та бүхэн манайд очоорой. Бүгдээрээ үлгэрлэж байж энэ бүхнээс гарна. Бөмбөгөр цагаан гэрээ бариад, хоёр үнээ, 20 ямаа, хонно харуулаад амьдраад байх цаг ирсэн. Б.Чойжилсүрэн ах та чин элэгтэй хүн. Чин элэгтэй байж чадахаа өөрөө харуулаарай. Мөн бүгд тал нутаг руугаа гаръя. Үүнийг тайлбарлахад маш их цаг хугацаа авна. Гэхдээ би бага багаар тайлбарлана даа” хэмээсэн. Тухайн үед түүний энэ үгийг гишүүд наргиан наадам болгоод өнгөрсөн бол УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “Өчигдрийн хуралдаанд С.Жавхлан гишүүний бусад гишүүдээ монгол гэрт амьдраад үз гэсэн үгийг ихэнх нь инээж хүлээн авсан. Энэ үгийг шоолох хэрэггүй. Монгол хүн гэрээ барихдаа газраа сонгож, шалаа тавих, тооно, хаалгаа уулын орой чиглүүлэх, ханаа дугуйлахаас эхлээд бүх юмыг нарийн учиртай бодож хийдэг. Төр барихад эдийн засаг, төрийн албаны чиг үүрэг, хууль засаглал, төрийн хүний сэтгэлээ засах чадвар гээд бүх зүйл яг үүнтэй адил цогцоор нийлж байж төр зөв оршино гэж боддог. Зөв барьсан гэр дулаан, салхинд хийсэхгүй, газраа зөв сонгосон бол цасанд даруулж, үерт автахгүй л дээ. 81 унштай байх ёстой гэрт 800 унь хэрэггүй. Төрийн албыг ийм л болгосон. Өнгөц харвал хэдэн минутын үг мэт боловч ухааж бодвол олон юм бодогдохоор үг хэлжээ. Харих замд толгойд эргэлдсээр, хоолоо идсэн ч бодогдсоор. Өөриймсөг мөртлөө улс оронд төрийн ухаан дутаад байгааг л хэлчихсэн” хэмээн өөрийн байр сууриа илэрхийлсэн байна.

А.Бямбажаргал: УИХ-ын шийдвэр парламентат ёсны хувьд халтай үйл явдал болмоо

/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн ухааны доктор/

Өнгөрсөн долоо хоногт УИХ-аас зарим хуулиудыг буцаах тухай тогтоол гаргасан. Энэ талаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал “Хууль тогтоох ажиллагаа өөрөө нарийн технологи буюу өөрийн гэсэн тодорхой үе шаттай байдаг. Эдүгээ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль ёсоор юуны өмнө хууль тогтоох ажиллагаа нь хууль санаачлах эрх бүхий субъект санаачлах, улмаар түүнийг холбогдох байнгын хороогоор хэлэлцэж нэгдсэн хуралдаанд оруулах эсэхийг шийдэж, үүний дараагаар УИХ-ын нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлэх, мөн байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх, зарчмын зөрүүтэй болон нэг асуудлаар хоёр өөр хуулийг төслүүд байвал тэдгээрийг нэгтгэн байнгын хороо төслийг хэлэлцэж УИХ-ын нэгдсэн чуулганаар эцэслэн батлагддаг. Энэ нь хууль батлах процедур өөрөө хуульд нарийвчлан заасан олон үе шатыг дамжиж байж сая хууль батлагддаг болохын нотолгоо юм. Тэгвэл саяын УИХ-ын тогтоол угтаа бид дээрх шат дамжлагаар шүүгдэн нэгэнт батлагдсан хуулиудыг хуульд заагаагүй арга замаар буцаасан. Энэхүү үйл явдал Монгол Улсын парламентын түүхэнд хүчин төгөлдөр хуулийг хууль санаачлагчид нь буцааж буй анхны тохиолдол болж байгаагаас гадна парламентат ёсны хувьд халтай үйл явдал болж байна” хэмээн ярьжээ.

ХААН БАНК	НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙР
Монгол орон даяар хамгийн өргөн сүлжээг бүрдүүлсэн банкинд тогтвор суурьшилтай ажиллах, бүтээлч сэтгэлтэй залууст дараах ажлын байрыг санал болгож байна.	
Өрсөлдөхгүй цалин урхишуулал	Хөгжих дэвсгэр боломж
ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР-ЭМЧ	
Өргөдөл хүлээн авах хугацаа: 2016.09.09-ний өдрийг дуустал	
Тавигдах өрөнхий шаардлага:	<ul style="list-style-type: none"> Ангалах ухааны их, дээд сургуулийг ерөнхий зөвшөөрөх, сувилалын чиглэлээр төгссөн Ангалах ухааны нарийн мэргэжил (уламжлал, дотор) ийн мэдлэгтэй байх; Компьютерийн ажил мэдлэгтэй; Албан ёсныг боловсруулах чадвартай.
Тусгай шаардлага:	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн салбарт баа эмч, сувилалчид 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай; Европ болон Уламжлалт эмчилгээ, бариа засал зэрэг чадвартай; Ажлын ачаалал даах чадвартай; Банкны үйлчилгээ, бодлогод нийцэх, үнэн шударга, ёс суртахуун болон ёс зүйн хэм хэмжээг сайн ажиглах чадвартай.
Хувь хүнд тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> Бие даасан бүрдээг хариат бүс шийдвэр гаргах чадвартай; Хувийн зохион байгуулалт сайтай, эмч цөлөгтэй; Ажлын ачаалал даах чадвартай; Банкны үйлчилгээ, бодлогод нийцэх, үнэн шударга, ёс суртахуун болон ёс зүйн хэм хэмжээг сайн ажиглах чадвартай.
Бүрдүүлэх материал:	<ol style="list-style-type: none"> Боловсролын гэрчилгээний хуулиар; Иргэний үнэмлэх; Оршин суугаа харомны тодорхойлолт; Урьд нь ажиллаж байсан бол тухайн ажлаасаа ажил байдлын тодорхойлолт авах; ХААН Банкны "Ажилд орохыг хүсэгчийн амжилт" нь бүрэн гүйцэт, үнэн зөв батлагдсан байх.
Ангальт Төв ХААН Банкны байрнд биеллэн ирэх эрэг эгжл: www.khanbank.com зангаар нөмөрч, Ажлын байр хуралдаанаар зангаар зангаар хэлбэрээр болж илгээх.	ЖИМ: Зөвхөн эдийн засаг шааргуулалтад тэнцсэн хүмүүстэй холбоо барина. Бүрдүүлсэн материалыг буцаан олгохгүй боловч ивээлээр үү.
Хаяг: Сүхбаатар дүүрэг 4-р хороо, Сөүлийн гудамж -25, ш/х-192, Улаанбаатар 14250 Утас: 332333	

Ипотекийн 5 хувийн зээлийг санхүүжүүлэх боломжгүй болжээ

Сүүлийн үед ипотекийн таван хувийн зээлийг зогсоолоо гэх мэдээлэл хэвлэлүүдээр гарснаар Монголбанк нийм шийдвэрийг гаргасан гэхойголт олон нийтийн дунд бий болоод байна. Харин Монголбанкны зүгээс “Ипотекийн таван хувийн зээлийн хөтөлбөрийг зогсоох ямар ч шийдвэр гаргаагүй” гэжээ. Харин Монголбанк ипотекийн таван хувийн зээлийг санхүүжүүлэх боломжгүй болсноо Засгийн газар болон арилжааны банкуудад мэдэгдсэн байна. Өнгөрсөн хугацаанд Монголбанкнаас хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах хөтөлбөр болон Засгийн газраас хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрүүдэд олгогдсон санхүүжилт нь төгрөгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн. Үүнтэй холбоотойгоор Монголбанк цаашид эдийн засагт их хэмжээний мөнгө нийлүүлэхгүй байх шаардлага бий болоод буй. Үүний тулд Монголбанк санхүү бодлогын хүүгээ нэмэгдүүлж, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж

эхэлсэн.Тийм учраас бодлогын уялдаа, холбоот хангах зорилгоор ипотекийн таван хувийн зээлийн хөтөлбөрт мөнгө нийлүүлэхгүй гэж Төв банк үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Төв банкны бодлогын хүүг нэмэгдүүлсэн шийдвэр нь ам.долларын ханшинг хэт өсөлтийг тогтворжуулж, төгрөгийн өгөөжийг хадгалахад үр дүнгээ өгч эхэлсэн. Ийм үед ипотекийн таван хувийн хөтөлбөрөөр дамжуулан зах зээлд мөнгө нийлүүлбэл, дээрх бодлогын үр дүнд алдагдуулж, ханш эргээд өсөх нөхцөлийг бүрдүүлэхээр байгаа юм. Ипотекийн таван хувийн зээлийн хөтөлбөр нь Засгийн газраас батлагдсан журмын дагуу хэрэгждэг. Тийм учраас шаардлагатай бол Засгийн газар тодорхой эх үүсвэрийг шийдсэнээр хэрэгжүүлэх боломжтой аж. Дашрамд дурьдахад, өнгөрсөн хугацаанд ипотекийн таван хувийн зээлд 3924 иргэн хамрагдаж, нийт 172.9 тэрбум төгрөгийн зээл олгогджээ.

ЭДИЙН ЗАСАГ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ТӨРИЙН БОДЛОГООС ЗУГТСАН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ТАТАХ ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

П.Очирбат: Гадаадын хөрөнгө оруулагчид улсын бодлогыг хардаг

/Монгол Улсын анхны ерөнхийлөгч/

“Манай улсад зүгээр нэг биш бодитой эдийн засгийн хүндрэл гарлаа. Үүнийг дагаад эрдэс баялгийн салбарын зах зээл, эрэлт тодорхой хэмжээгээр буурсан. Нэг талаас нь харвал ийм. Нөгөө талаас зах зээлийн үнэ нэлээд буурсан нь ашиг орлогод их сөрөг нөлөө үзүүлээ. Энэ болгоноос үүдээд хөрөнгө оруулагчид нэлээн саадсан. Бид нэг зүйлийг хатуу ойлгодог шүү дээ. Гадаадын хөрөнгө оруулагчид гэдэг чинь нэг талдаа өөрсдөө ашиг олох гэж хөрөнгөө зольж байгаа улс. Ашиг олохгүй юманд хөрөнгөө зардаг ухаан муутай хөрөнгө оруулагч, бизнесмен дэлхийд их ховор байна л даа. Тийм учраас гэдг чинь зах зээлд ялангуяа Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг авдаг, борлуулдаг зах зээлийн араншин яах нь вэ гэдгийг нэлээд хардаг. Мөн хөрөнгө оруулж байгаа улсын маань бодлого хэр зэрэг цэгцтэй, тууштай, тогтвортой байна вэ. Төрийнх нь бодлогоо шалтгаалан бидний эрсдэл буурах, нэмэгдэх үү гэдгийг үнэлж цэгцнэдэг. Энэ мэтчилэн олон янзын хүчин зүйл нөлөөлснөөс болж хөрөнгө оруулалтын хэмжээ ч багаслаа. Бид чинь энэ Discover гэдэг уулзалтыг ерөөсөө дэлхийд чөлөөтэй явж байгаа хөрөнгийг аль болохоор Монгол улсын эдийн засагт оруулахын тулд л хийж байгаа юм.


Петер Акерли:
Гадаадын хөрөнгө оруулагчид хумигдсан нь Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн

/Эрдэнэ Ресурс Девелопмент” компанийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал/

“Эрдэнэ Ресурс Девелопмент”

МЭДЭЭЛЭЛ

Авто замын бүтээн байгуулалтад хөнгөлөлттэй зээлээр дэмжлэг үзүүлэхийг хүсэв



Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Мурат Карагөзийг өчигдөр хүлээн авч уулзлаа. Хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд зам, тээврийн салбар чухал байр суурь эзэлж байгаа бөгөөд 1994 оноос хойш Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Монгол Улстай хамтын ажиллагаагаа өрнүүлж энэ хугацаанд хэд хэдэн бодитой

төсөл арга хэмжээг хэрэгжүүлээд байгаа аж. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хархорин суманд орших Хөшөө цайдам чиглэлийн 46 км авто замыг ашиглалтад оруулахаас гадна Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс Эрдэнэзуу хийд хүртэл 2.4 км хатуу хучилттай зам тавих шинэ төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа юм. Харин Агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хоёр улсын холбогдох

байгууллагуудын хооронд өмнө нь олон удаагийн уулзалт ярилцлага зохион байгуулсан байдаг. Энэхүү асуудалд Монголын талаас баримталж байгаа байр сууринд өөрчлөлт ороогүй гэдгийг сайд Д.Ганбат уулзалтын үеэр онцолж байв. Түүнчлэн Монгол Улсад төмөр замын бүтээн байгуулалт хийгдсэнээр 5000-6000 ачааны вагоны хэрэгцээ шаардлага гарах тооцоо судалгаа бий. Энэ бүтээн байгуулалтад тодорхой саналуудыг хүлээн авч хамтарч ажиллахад бэлэн байгаагаар сайд Д.Ганбат илэрхийлсэн юм. Харин элчин сайд Мурат Карагөз дээрх саналуудыг хүлээн авч “Засгийн газрын гишүүний чухал ач холбогдолтой албыг хашиж байгаа мэргэжлийн хүн гэдэг утгаар нь Шинэ засгийн газар таны туршлагыг бүрэн дүүрэн ашиглаж, эдийн засгийн хөгжлөө тодорхойлно гэдэгт найддаг байна” гэв. Мөн хоёр улсын харилцаанд харилцан визгүй зорчих, харилцан ашигтай хамтын ажиллагаатай байхыг эрхэмлэж, иргэний агаарын тээврийн чиглэлд тавих саналыг бүтээлчээр хүлээж авахыг хүссэн юм.



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

компани “Зуун мод” гэх молюбдений төсөлд хайгуулын ажил хийсэн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр эдийн засаг 17.3 хувийн өсөлттэй болж эхэлсэн. Мөн Монголын уул уурхайн компаниудын хувьд том боломж бий болон гадаадын бирж дээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж байлаа. Гэсэн ч 2015, 2016 онд хайгуулын лицензийг зогсоосон. Энэ нь салбарын хөгжлийг доош татаж, хөрөнгө оруулагчдад алдахад хүргэсэн явдал боллоо. Монгол Улсад Ашигт малтмалын салбарыг дэлхийд нээлттэй болгохын тулд хайгуулын ажлыг хийсэн нь үр дүнтэй байсан. Шинэ Засгийн газар уул уурхайн салбарыг дэмжсэн, илүү ил тод, тодорхой бодлого барин ажиллах болсонд таатай байна. 2015 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалт хумигдсан явдал нь Монголын эдийн засгийн бууралтад хамгийн их сөрөг нөлөө үзүүлсэн юм. Алтны олборлолтыг зардал багатайгаар хийн эдийн засагт нөлөөлөх боломж байгаа юм. Монгол Улсын хувьд уул уурхайн баялгаа эдийн засгаа сайжруулахад л ашиглах нь тохиромжтой. Өнөөгийн Монгол Улсын эдийн засаг тогтворгүй, уналттай байгаа ч манай компани үйл ажиллагаагаа хэвийн явуулж,

хайгуулын ажлуудаа дараагийн шатанд гаргах болно. Тухайлбал, алтны олборлолтыг зардал багатай хийгээд эдийн засагт нөлөөлөх боломж бий. Энэ нь хоёр талд ашигтай үйл явц байх болно.

Ч.Отгочулуу: Улс төр, уул уурхайн төлөвлөгөө зөрчилдөж, бие биеэ татаж унагаад байна

/Эрдэнэ Монгол компанийн гүйцэтгэх захирлын ажлын алба харууцсан захирал, ерөнхий эдийн засагч/

“Манай улс жижиг орон. Худалдааны томоохон хөрш хоёр оронтой. Хоёр түншийн эдийн засгийн бодлого нь манайхаас огт өөр. Тухайлбал, төрийн өмчит банк байна. Төрийн өмчтэй банкуудаасаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авчирдаг. Ийм үед стратегийн ордуудад төр тодорхой хэмжээний хяналт тавих нь муу зүйл биш. Гэхдээ үүнийг их зөв удирдаж хэрэгтэй. Яагаад гэвэл төр өөрөө зохицуулагч. Нөгөө талаас бизнес

хийгээд хувийн хэвшлийнхэнтэй өрсөлдөж болохгүй гэж үздэг. Энд нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Тавантолгой дээр гурван компан үйл ажиллагаа явуулж байна. Мэдээж энд өрсөлдөөн байгаа. Гэхдээ Эрдэнэ Тавантолгойн харьцангуй хямд үнээр үнэлүүлээд байгаагийн шалтгаан нь 2012 оны сонгуулийг угтаж, нэлээд хатуу нөхцөлтэйгөөр гэрээ хийсэнтэй холбоотой. Тэр гэрээний үр дүн нь энэ. Энэ алдааг давтахгүйн тулд нэг цонхны бодлогыг хэрэгжүүлээ. Энэ бодлого нь төрч бай, хувийн хэвшил ч бай хоорондоо өрсөлдөхгүй нэг цонхны бодлогоор гадагшаар гэдэг. Бие биенийхээ үнийг уралдаж буулгадаг нь буруу гэдэг бодлого юм. Ийм байдал үүссэн нь уул уурхайн компани, салбарын буруу биш. Хуучин төрийн өмчийн компаниудыг хүний

хөгжил сангийн тухай хуулиар өрсөлдөж болохгүй гэж үздэг. тухайн компанийн ТУЗ, ерөнхий захирал нь хэн байх, орлогыг нь яаж зохицуулах вэ гэдгийг шийддэг. Ерөөсөө нэг ч төгрөг үлдээлгүй хүний хөгжил сан руу авдаг. Тэр байтугай ирээдүйн орлогыг нь аваад өөр компанид хэрэгжүүлдэг. Ийм л байсан. Тэгээд үнэ өсөөд байдаг. Бид байгаа юмаа гаргаад байдаг. Одоо харин үүнээс сургаж авах хэрэгтэй. Сая гадаадын төлөөлөгчид ч хэлж байна. Уул уурхайн салбарынхаа боломжийг ашиглаж гэвэл урт хугацаанд тогтвортой байлгах хэрэгтэй гэж. Сүүлийн 20 жилийн хугацаанд манайх их өөрчлөлт хийж ирсэн. Энэ алдааг битгий давтаачээ. Тэгэхээр бид уул уурхайн салбарыг улстөрчдөөс салгах ёстой. Учир нь уул уурхайн төлөвлөгөө 50-60 жилээр явагддаг.

Харин улс төрийн төлөвлөгөө дөрөв дөрвөн жилээр явдаг. Энэ хоёр зөрчилдөөд бие биенээ татаж унагаад байна. Тиймээс улстөрчид нь улс төрөө, уул уурхайн уул уурхайгаа хий.

Г.Батсүх: Уул уурхайн компаниуд нэгдсэн үнийн бодлогыг барьж чадаагүйгээс бие биеэ түлхэж унагасан

/“Оюутолгой” компанийн ТУЗ-ийн дарга, Элчин сайд/

“Дэлхийн зах зээлд уул, уурхайн гаралтай түүхий эдийн үнэ унасангай холбогдоод уул уурхайн үйлдвэрүүдийн байдал хүндэвтэр байгаа. Цаашид энэ байдлаас гарах арга замыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гаргаж байна. Юуны өмнө бид нүүрсний экспортын үнийн асуудалд нэг цонхны бодлогоор хандах нь чухал. Мөн нүүрснийхээ экспортыг нэмэгдүүлэхийн тулд дэд бүтэц гэх мэт анхаарах асуудлууд байна. Өнгөрсөн хугацаанд үнийнхээ бодлогыг нэгдсэн байдлаар явуулж чадаагүй. Энэ нь гадаадын худалдан авагчид болон манай Монголын нүүрсийг хэрэглэгчдэд давуу тал олгосон. Өөрөө өөрсдийгөө сул тал руу түлхэж унагасан. Энэ асуудалд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ер нь компанийн үйл ажиллагаа зөв менежментээс хамаарна. Мэдээж менежмент хүнээс хамааралтай. Тийм учраас уул уурхайн үйлдвэрлэлийг мэргэжлийн төвшинд бэлтгэгдсэн боловсон хүчин удирдан, зөв чиглүүлдэг явбал ялгаагүй үр ашигтай ажиллах ёстой. Төрийн өмчид нь ч бай, хувийн ч бай адилхан хүнээс л шалтгаална. Тэгээд бодлого нь зөв байх учиртай.

АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА



✓ Зах зээлдээ тэргүүлэгч худалдааны компанид дараах ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж байна.

-МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

✓ Ажлын байрны зорилго:

Компанийн реклам сурталчилгаа, олон нийтийн харилцааны бодлогын хүрээнд харилцагчид, зах зээл, хэрэглэгчидэд чиглэсэн бүх төрлийн реклам сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах, үр нөлөөг нь үнэлэх, дүгнэх, борлуулалтыг нэмэгдүүлэх

✓ Тавигдах шаардлага:

- ✓ Маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- ✓ Баримт бичиг боловсруулах, тооцоо судалгаа хийж, дүгнэлт өгөх чадвартай
- ✓ Илтгэх, танилцуулах, олон нийттэй харилцах өндөр үр чадвартай
- ✓ Удирдан зохион байгуулах, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй
- ✓ Хувийн зохион байгуулалт сайтай
- ✓ Багаар ажиллах чадвар сайтай

✓ Бүрдүүлэх материал:

- ✓ CV буюу өөрийн танилцуулга
- ✓ Бакалавр болон магистрын дипломын хуулбар
- ✓ Цахим үнэмлэхүйн хуулбар
- ✓ Сүүлийн 3 сард авахуулсан өнгөт 3x4 цээж зураг 1%

Холбоо барих:

Материал хүлээн авах хаяг:

Материал хүлээн авах эцсийн хугацаа:

9595-0095

Erinbileg1@gmail.com

2016.09.11

Хүчингүйд тооцов

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Ү-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул хүчингүй тооцов.

тооцов.

Цагаан шилмүүс ХХК-ийн 5189527 регистрийн дугаартай, 9011134046 улсын бүртгэлтэй компани нэрээ өөрчилж байгаа тул хүчингүйд тооцов.

Буян Маргад Од ХХК нь 5362318 регистрийн дугаартай тамга гээгдүүлсэн тул хүчингүйд

MINFO.

СПОРТ



Паралимпийн нээлтийн сониноос

Бразилын Рио де Жанейро хотноо 15 дахь удаагийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн паралимпийн наадам эхэлж, 161 орны 4300 тамирчны 23 спортын 528 багц медалийн төлөөх гал бутарсан тоглолтууд албан ёсоор эхэллээ. Гэмтэл ослоос эхлээд төрөлхийн болон ямар нэг байдлаар хөдөлмөрийн чадвараа алдсан, тахир дутуу болсон ч хүн спортын маш олон төрлөөр хичээллэн өндөр амжилт үзүүлж болдог гэдгийг энэ наадам харуулдаг байна. Энэ оны зуны 15-р паралимпийн хөтөлбөрт шинээр каное, паратриатлоны спортууд багтжээ. Паралимпод медалийн тоогоор тэргүүдэг ОХУ-н паралимпийн баг энэ наадамд допингийн шийтгэлийн улмаас оролцохгүй. Саяхан тэд олон улсын арбитрийн шүүхэд ВАДА-гийн шийдвэрийн эсэргүүцэн давж заалдсан боловч үр дүнд хүрээгүй. Риогийн паралимпод манай улс түүхэндээ байгаагүй өргөн буюу найман тамирчдын бүрэлдэхүүнтэй оролцоно. Тус багт буудлага, хөнгөн атлетик, хүчний гурван төрөл, байт харвааны тамирчид багтаж байгаа юм. Наадмын нээлтийн ёслол энэ сарын 7-нд эхэлсэн бөгөөд сонин содон үзүүлбэрээр дэлхийн үзэгчдийг байлдан дагуулж чаджээ. Ингээд уншигчиддаа Паралимпийн нээлтийн сониноос сонирхуулъя.

-Риогийн паралимпийн наадмын 50 мянган тасалбар зарагджээ. Харин тасалбаргүй хүмүүсийн хувьд зурагтаараа үзэх боломжтой. Учир нь дэлхийн хэд хэдэн томоохон телевиз шууд дамжуулан үзүүлж байгаа юм.

-Энэ удаагийн паралимпод 160 гаруй орны 4350 тамирчин спортын 23 төрлөөр 500 гаруй багц медалийн төлөө өрсөлдөх юм. Паралимпийн наадам хамгийн анх 1960 онд Ром хотноо зохион байгуулагдаж байсан бөгөөд тухайн үед 23 орны 400 орчим тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорьж байсан аж. Тэгвэл энэ удаа 4350 тамирчин оролцож байгаа нь паралимпийн түүхэн дэх шинэ рекорд гэнэ. Өмнө нь ийм олон тамирчин тус наадамд ирж, оролцож байгаагүй юм байна. Өнгөрсөн жил гэхэд 4200 тамирчин оролцож байжээ.

-Паралимпийн нээлтийн ёслолд бүжиг дэглээч, уран бүтээлчид зэрэг мэргэжлийн багийнхан 500, сайн дурынхан 2000 оролцжээ.

-Рио де Жанейро хотноо өнгөрсөн сард зохион байгуулагдсан 31 дэх удаагийн олимпын наадамд энэ жил анх удаагаа дүрвэгсдийн баг оролцсон бол паралимпод ч гэсэн Сирийн дүрвэгсдийн төлөөлөл оролцсон байна. Сирийн дүрвэгсдийн багийг Ибрахим ал Хуссейн тэргүүлэн нээлтэд оролцжээ.

-АНУ-ын цанын тамирчин, паралимпийн медальт Эми Пурди нээлтийн үйл ажиллагааны бас нэгэн чимэг нь байжээ. Тэрбээр энэ удаа мэргэжлээ сольж, бүжигчин болсон гэнэ. Эми бүжгийн хувцас өмсч, талбайд самбаа бүжиглэжээ. Тамирчин бүсгүй 2014 оны Сочигийн паралимпос хүрэл медаль хүртэж байв.

-Нээлтийн үйл ажиллагааг гурван найруулагч найруулжээ. Зохиолыг Марсель Рубенс бичсэн бол уран бүтээлчдийг Виз Муниз ерөнхийд нь хариуцаж, Фред Желли загварыг нь гаргасан байна. 2500 гаруй хүн нэг тайзнаа зүрхэн хэлбэрийг үүсгэсэн нь мэдрэмж, бэрхшээл, эв нэгдэл, хайр сэтгэлийг харуулсан байна.

-Наадам энэ сарын 18-ны ням гарагт өндөрлөнө.



Күниэда Шинго: Би ялалдаах дургүй

-Япончуудын хувьд та хоёр хоёулаа л бахархал болсон хүмүүс. Харин тамирчньхаа хувиар нэг нэгнийгээ товчхон тодорхойлохгүй юу?

Санада Такаши: Намайг тэргэнцэртэй теннисээр хичээллэх эхлэх тэр үед Күниэда Шинго аль хэдийнэ Японы шилдэг тамирчдын нэг болсон байлаа. Одоо ч гэсэн сайн тамирчин хэвээрээ. Миний хувьд хожуу энэ спорт руу орсон ч гэлээ, нас ойролцоо байсан юм. Гэхдээ би түүнийг ах гэж хүндэлдэг. Түүний гаргасан амжилтыг давтахын төлөө л явна даа /инээв/. Миний ах, бас дэлхийн номер нэг тамирчин гэдэг утгаар нь түүнийг үргэлж хүндэлж явдаг.

Күниэда Шинго: Түүнийг надад ингэж атаархдаг гэж бодсонгүй шүү /инээв/. Такаши 20 гарсан хойноо теннисээр хичээллэж эхэлсэн. Анхнаасаа л ирээдүйтэй тамирчин гэж үнэлэгддэг байсан хэдий ч, тухайн үед өөрийгөө тэр бүр дайчилдаггүй байсан /инээв/. Харин гурван жилийн өмнөөс би өөрийн сургуулилтаа хийдэг теннисний төвд түүнтэй хамт бэлтгэл хийдэг болсон. Тэр үеэс хойш чадвар нь тасралтгүй өссөн шүү. Риогийн олимп дөхсөн ч, түүнийг дэлхийн бусад тамирчидтай эн тэнцүү өрсөлдөх чадвартай гэж би хувьдаа боддог.

-Сагсанбөмбөг, суугаа валебол, уртын зайн гүйлт гээд тэргэнцэртэй иргэдэд зориулсан олон төрлийн тэмцээн бий. Тэр дундаас яагаад заавал теннисийг сонгосон юм бэ?

Шинго: Би есөн настай байхдаа нугасны хавдрын улмаас суугаа болсон. Түүнээс хойш л тэргэнцэртэй амьдрах болсон доо. Суугаа болохоосоо өмнө бэйсбол, сагсанбөмбөгөөр тоглох дуртай байсан. Үнэнийг хэлэхэд теннисэнд тийм ч сонирхолтой байгаагүй. Сагсанбөмбөгийг л бусдаас илүүтэй сонирхож, түүнтэй холбоотой манга хүртэл цуглуулж, суугаа болсон ч сагсанбөмбөг тоглох юм шүү гэж бодож байлаа. Гэхдээ харамсалтай нь манай гэрийн ойролцоо сагсанбөмбөгийн баг байдаггүй байсан юм. Харин теннис тоглох дуртай ээж минь гэрийнхээ ойролцоо тэргэнцэртэй иргэдэд зориулсан сургалт хичээллүүлж эхэлсэн юм. Хааяа тэдний яаж тоглохыг харахаар очдог байлаа. Хэд хэд очсоны дараа би өөрөө ч гэсэн

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлгэдэл болсон зуны 31 дэх удаагийн олимпын наадам өнгөрсөн сард хаалтаа хийсэн. Тэгвэл энэ сарын 7-ны өдрөөс эхлэн Рио хотод 15 дахь удаагийн паралимпийн наадам ёслол төгөлдөр эхэллээ. Тиймээс энэ удаа Паралимпийн наадмын тэргэнцэртэй теннисний төрөлд Японыг төлөөлөн оролцож буй тамирчдын орон нутгийн хэвлэлд өссөн ярилцлагыг орчуулан хүргэж байна. Нугасны хорт хавдрын улмаас бага насандаа суугаа болсон Күниэда Шинго эдүгээ тэргэнцэрт теннисний төрөлд дэлхийн чансааг тэргүүлдэг төдийгүй энэ спортын "амьд сан хөмрөг" хэмээн нэрлэгдэх нь бий. Тэрбээр 2004, 2008, 2012 оны паралимпийн наадмаас алтан медаль хүртсэн юм. Харин Санада Такашигийн хувьд авто ослын улмаас суугаа болжээ. Тэрбээр Японы хийгээд дэлхийн олон нэр хүндтэй тэмцээнд аваргалж байсан юм. Ингээд тамирчдын өөрийн амьдрал, их спортын талаар сонирхолтой яриа өрнүүлснийг уншигчиддаа толилуулж байна.



хичээллэж эхэлсэн. Тэр үед 11 настай байсан гэж бодохоор би 20 гаруй жил энэ спортод зүтгэсэн байна.

Такаши: Миний хувьд 19 настай байхдаа авто осолд орж суугаа болсон. Нэг удаа эмнэлгийн коридорт байхдаа тэргэнцэртэй хүмүүс сагсанбөмбөг тоглож байгааг харсан. Намайг ихэд сонирхон харж байгааг анзаарсан тэд надаас "сагсанбөмбөг тогломоор байна уу" гэж асуусан юм. Харин би "Чадвал би тэргэнцэртэй теннис тогломоор байна" гэж хариулж билээ. Гэтэл тэдний нэг тэргэнцэртэй

тенисчдийн холбоонд элсээд "хамт тоглох уу" гэсэн. Ахлах сургууль хүртлээ теннисээр хичээллэж байсан болохоор шууд л зөвшөөрсөн дөө. Ингэж л би энэ спортод холбогдсон.

-Та хоёр ер нь хэзээнээс эхлэн дэлхийд гарч тоглохоор зориг шулуудаж байв?

-Шинго: Би ахлах сургуулийн гуравдугаар ангид байхаасаа Паралимп, Гранд Слами тэмцээнд оролцох зорилго тавьж эхэлсэн. Тэр үед долоо хоногтоо хоёр удаа сургуулилт

хийдэг байсан юм. Харин өмнөө том зорилго тавьсныхаа дараа дасгалжуулагчтайгаа жинхэнэ утгаараа бэлтгэлээ базааж эхэлсэн.

Такаши: -Анхандаа надад сургуульдаа сурацлах, мөн ажил хийх шаардлага байсан учраас спортоор хичээллэж эхэлсэн даруйдаа л теннисийг амьдралынхаа гол утга учир болгож чадаагүй. Тийм боломж ч байгаагүй. Гэхдээ хаяж ч чадаагүй /инээв/. Дараа нь Сайтама дахь Тоурет компанид ажиллаж эхэлсэн минь эргэлтийн цэг болж өгсөн. Захирал маань надад анх Паралимпод оролцох санал тавьсан. Тэр үеэс бэлтгэл сургуулилтад анхаарлаа хандуулж, дэлхийн тамирчидтай өрсөлдөх боломж нээгдсэн юм.

-Тэргэнцэртэй теннисний спортын хамгийн гайхамшигт чанар нь юу байдаг юм бол?

Шинго: Тэргэнцэртэй теннис хоёр үетэй байдаг бөгөөд дүрмийн хувьд жирийн талбайн теннисстэй адил. Теннис тоглоход хөгжилтэй бас эрүүл мэндэд ч хэрэгтэй. Тэргэнцрээ оновчтой удирддахаас гадна хурдан шаламгай хөдөлгөөн, бөмбөгнийхөө хөдөлгөөний тооцоолох гэх мэтээр тухайн тамирчнаас маш их авхаалж самбаа шаарддаг. Эцэст нь хэлэхэд, би өөрийгөө тэргэнцэртэй харьцах техникийг хамгийн сайн эзэмшсэн хүн гэж боддог. Жирийн хүнтэй яг адил теннис тоглохыг хүсч байна. Гэхдээ одоонодоо арай л болоогүй байгаа.

-Тоглолтын явцад олон янзын хөдөлгөөн хийх шаардлагатай болдог шүү дээ. Үүнээс болоод унаж бэртэж байсан тохиолдол цөөнгүй байх даа?

Шинго: Унасан тохиолдол надад одоогоор байхгүй. Такаши л их ойчдог доо.

Такаши: Тийм ээ. Энэ жил гарснаас хойш бүх л бэлтгэл дээр унасан шүү. Ингээд бодохоор тэргэнцэртэй теннис тийм ч гайхалтай спорт биш бололтой. Тэргэнцэртэй байж болохгүй. Тэргэнцэртэй байж болохгүй.

Шинго: Гэхдээ энэ тамирчны чадвартай огт хамаагүй. Ойчдог хүн, ойчдоггүй хүн гэж байдаг гэж ойлгож болно. Дэлхийд чансаагаараа тэргүүлдэг Стефани Худет ч гэсэн унадаг л биз дээ. Магадгүй үүнд л энэ спортын гайхалтай чанар оршдог байх. Унасан ч, эргэж босох тэнхээтэй байна гэдэг

хамгийн чухал.

Такаши: Би албаар унадаг байхгүй юу. Бөмбөгтөө хүрч чадахгүй уначихаад, илүү хичээл гэсэн бодолтойгоор босч ирдэг /инээв/. Үнэнийг хэлэхэд, тэргэнцрийн өндөр намаас шалтгаалж унах тохиолдол бий. Би бие жижигтэй учраас гадны өөрөөсөө чац томтой тамирчидтай тоглохын тулд тэргэнцрээ өндөрсгөн шаардлагатай болдог юм. Үүнээс болоод ойчих тохиолдол их. Ер нь өөрөө өөрийгөө ялан дийлэх нь хамгийн чухал юм даа.

-Энэ спортоор хичээллэж эхэлснээр та хоёрын амьдралд гарсан өөрчлөлт?

Шинго: Зан чанарын тухайд хүүхэд байх үеэс огт өөрчлөгдөөгүй. Угийн ялагдах дургүй. Компьютер тоглоом, сагсанбөмбөгт ч гэсэн ялагдах дургүй, их шартай хүүхэд байж билээ. Ялахын тулд байнга бэлтгэл сургуулилт хийдэг тэр зан одоо ч хэвээрээ. Тэргэнцэртэй теннисний спортыг сонирхож эхэлснээр би "Хүн өөрийгөө юунд хүрч чадахыг огт мэддэггүй юм байна" гэдгийг ойлгож авсан. Анх дэлхийн шилдэг тамирчин болох үедээ өөртөө огт итгээгүй. Гэхдээ одоо эргээд болохын тулд миний хичээл зүтгэл дутуу дулимаг байсан юм билээ. Бэлтгэл сургуулилтаа үргэлжлүүлж, шилдэг тамирчин болохын тулд юм багаасаа л эхэлдэг. Эхлээд нэг тоглолтод ялна. Дараа нь гурван тоглолт. Үргэлжлээд нэг улиралд ялалт байгуулж явсаар эцэст нь дэлхийн хэмжээний тамирчин болдог юм.

Такаши: Миний хувьд улсын аврага болж, олон улсын тэмцээнд явах үед миний амьдралд том өөрчлөлтүүд гарч эхэлсэн. Олон өөр улсын соёл, зан заншилтай танилцанаар теннис ч, хувь хүн талаасаа ч хөгжсөн гэж ойлгодог.

Шинго: Худлаа яриад байх юм. Үнэнээ хэл л дээ /инээв/

Такаши: Үнэн

-Цаашдын зорилгоосоо сонирхуулахгүй юу?

Шинго: Дэлхийд чансаагаараа тавдугаарт эрэмбэлэгдэж байгаа. Цаашдаа илүү их бэлтгэл сургуулилт хийж, нэгт бичигдэх миний эрхэм зорилго.

Такаши: Харин би Рио де Жанейро хотод болох паралимпос алтан медаль хүртмээр байна. Дараа нь Токиогийн олимпод ч оролцоно гэсэн зорилгыг өөртөө тавьсан.

СПОРТ-ХУАНДИ



Есдүгээр сарын 17:

Энэ сарын 17-ноос ирэх сарын 1-ний өдрийг хүртэл Хоккейн дэлхийн цомын тэмцээн Канадын Торонто хотноо зохион байгуулагдах гэж байна. "Дэлхийн цом"-ын тэмцээн бол мөсөн талбайн тамирчдын хувьд олимпын наадам байдаг. Энэ наадамд дэлхийн зургаан шилдэг баг, "Дэлхийн цом"-д зориулан байгуулсан Европ, Хойд Америкийн багууд оролцоно.




Есдүгээр сарын 4:

Италийн Гранд при Формула-1 уралдаан энэ сарын 4-нд Италид эхэлсэн. 67 дахь улирлын уралдаанд 22 тамирчин оролцжээ.



Есдүгээр сарын 7-10:

Сагсанбөмбөгийн "Чингис хаан" олон улсын цомын тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж байна. Тэмцээнд Монгол Улсын үндэсний шигшээ нэг, хоёрдугаар баг, залуучууд, оюутны шигшээ, БНАСАУ, БНСУ, Өвөрмонголын Хөх хотын их сургууль, Буриадын баг өрсөлдөж байгаа юм.



Есдүгээр сарын 1:

Олон улсын "Weltklasse Zurich -2016" хөнгөн атлетикийн тэмцээн Швейцарын Цюрих хотноо эхэлсэн. Энэхүү уралдааны шагналын сан 40 мянган ам.доллар байдаг бөгөөд энэ жил олимпын аварга болсон шилдэг тамирчид оролцсон. Сонирхуулахад, 2008, 2012 оны олимпын аварга тамирчин Шанон Роубури энэ уралдааны 1500 метрийн зайд түрүүлжээ. Түүний хувьд Риогийн олимпод дөрөвдүгээр байрт орж, медаль хүртэж чадаагүй байсан юм.



Есдүгээр сарын 3-11:

Өмнөд Солонгосын Киджан хотод Эмэгтэйчүүдийн бэйсболын дэлхийн цомын тэмцээн үргэлжилж байна. Тэмцээнд дэлхийн 12 орны шилдэг бэйсболчид цугларан авхаалж самбаагаа сорьж байгаа юм. Эдүгээ тэмцээний хоёрдугаар үе эхэлжээ.



Есдүгээр сарын 1-14:

Олон улсын шатрын олимпиад Азербайжаны хамгийн том хот болох Баку хотноо энэ сарын 1-14-ний өдрүүдэд үргэлжилж байна. Тэмцээнд 176 орны тамирчид ирж оролцож буй. Тэгвэл яг одоогийн байдлаар Германы баг тэргүүлж, Украины оюун ухааны спортын тамирчин хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна. Харин Энэтхэгийн баг гуравд бичигдэж байгаа юм.



Rio 2016
JOGOS PARALÍMPICOS



Есдүгээр сарын 7-18

Энэ өдрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн паралимпийн наадам Бразилын Рио де Жанейро хотноо зохион байгуулагдаж байна. Энэ удаагийн паралимпийн наадам оролцсон тамирчдынхаа тоогоор шинэ рекорд тогтоож буй. Тус наадамд 160 гаруй орны 4350 тамирчин оролцож байна.



МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Улиралд

64

дугаар

Манай сонины IV улирлын захиалга
үргэлжилж байна

ЗАХИАЛГЫН ҮНЭ

18000



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025



ХӨЛБӨМБӨГ



Ì î ó ð è í ü î vs ï â ï



Английн премьер лигийн дөрөвдүгээр тойргийн хүрээнд алдарт "Манчестер Юнайтед" клуб талбайдаа нэг хотын баг болох "Манчестер Сити"-г хүлээж авч, Манчестерын дерби тулааныг хийх гэж байна. Өмнө нь энэ хоёр багийн тоглолтыг зүгээр л Манчестерын дерби гэж л тодотгодог байлаа. Харин энэ улиралд Пеп Гвардиало болон Жозе Моуриньо нарын ээлжит тулаан гэдгээрээ илүү онцгойрч байгаа юм. Испанид "Реал" болон "Барселона" гэсэн агуу түүхтэй хоёр багийг удирдаж, хоорондоо тулж явсан дэлхийн шилдэг дасгалжуулагчид Англид Манчестер хотын хоёр багт ирснээр дахин сонгодог тулаанаа үргэлжлүүлэх гэж байна. Тиймээс л Английн премьер лигийн дөрөвдүгээр тойргийг хөлбөмбөг сонирхогчид тэсэн ядан хүлээж байгаа нь гарцаагүй. Энэ улиралд премьер лигт түрүүлэх магадлал хамгийн өндөр гэгдэж байгаа хоёр багийн тоглолт маргааш Монголын цагаар 20:30 цагаас эхлэх юм.



учрыг олж, 1:0-ээр хожсон.

2010-2011 оны Аваргуудын лиг. Нэг хэсэг шөвгийн 16-гаас дээшээ гарахаа больсон байсан "Реал Мадрид" Моуриньогийн хамтаар хагас шигшээд шалгарч гарч ирэх нь тэр. Тэгэхдээ заналт өрсөлдөгч "Барселона"-тай учраа таарах нь тэр. Дахиад Пеп болон Моуриньо аваргуудын лигийн хагас шигшээд учраа таарч байгаа хэрэг. Гэхдээ өөр багтай. Эхний тоглолт 2011 оны гуравдугаар сард "Реал"-ын талбайд болоход "Барса" өрсөлдөгчөө 0:2-оор хожсон. Харин хариу тоглолтод хоёр баг 1:1-ээр тэнцсэн билээ. Пеп болон Моуриньо хожлын харьцаа 4:2 болов.

Мөн 2011 онд хоёр баг наймдугаар сард Испанийн супер комд учраа таарч, 2:2-оор тэнцсэн. Харин тоглолтод "Барса" өрсөлдөгчөө 3:2-оор буулгаж авч, Пеп хожлын тоогоо нэгээр нэмэв. Харин 2011 оны есдүгээр сард "Реал" талбайдаа "Барса"-г хүлээж авч, 1:3-аар хожигдсон юм. Дахиад л Моуриньо ялагдал хүлээн. Мөн 2012 оны нэгдүгээр сард Эзэн хааны цомын тэмцээнд "Барса" заналт өрсөлдөгчөө 2:1-ээр хожсон. Испанид болсон Пеп болон Моуриньогийн тулаан иймэрхүү дууссан билээ. Пеп илүү нь байсан. Харин одоо Манчестерын багуудтай хэрхэн тулахыг харах л үлдлээ.

Манчестер Юнайтед vs Манчестер Сити

2016-2017 оны улирал эхлээд гурван тойргийн ард гараад байгаа билээ. Тэгвэл гурван тойргийн дараах байдлаар хожигдолгүй гурван баг байгаагийн хоёр нь Манчестер хотын клубүүд байна. "Сити"-гийн хувьд гурван хожилтой, +6 бөмбөгтэй хүснэгтийг тэргүүлж байгаа. Харин "Манчестер Юнайтед" +5 бөмбөгтэй учир гуравдугаар байрт бичигдэж байгаа юм. Манчестер хотын багууд дөрөвдүгээр тойрогт учраа таарч байгаа нь анх удаагийнх биш ажээ. Өдгөөгөөс 11 жилийн өмнө буюу 2005 оны есдүгээр сарын 10-нд "Олд траффорд" цэнгэлдэхэд тулж байж. Тэр үедээ аль аль баг нь эхний гурван тойргоос хожил аваад байсан байна. Яг одоогийн нөхцөл байдалтай

ижилхэн. Түүх дахин давтагдаж байгаа нь энэ. Хүчирхэг хоёр баг дэлхийн хамгийн дасгалжуулагчидтайгаар тулж байгаа гэдгээрээ анхаарал татаж байна. Хоёр багийн хувьд сүүлийн таван удаагийн учраа таарч тоглосон тоглолтын хоёрт нь "Сити", хоёрт нь "Манчестер Юнайтед" хожсон. Харин үлдсэн нэг тоглолтод тэнцээд байгаа юм. Премьер лигт шүү дээ. 2015 оны гуравдугаар сарын 25-нд "Олд траффорд" цэнгэлдэхэд тулахад "Сити" өрсөлдөгчөө 0:3-аар буулгаж авч байсан. Дараа нь арваннэгдүгээр сарын 2-нд дахиад тулахад мөн л "Сити" 0:1-ээр хожсон юм. Харин 2015 оны дөрөвдүгээр сарын 12-нд тулахад "Улаан чөтгөрүүд" 4:2-оор хожсон бол өнгөрсөн хавар буюу гуравдугаар сарын 20-нд мөн "Юнайтед" өрсөлдөгчөө 1:0-ээр буулгаж авчээ.

Жозе Моуриньо болон Пеп Гвардиола

Манчест хотын багуудын хоорондоо тулж байсан үүх түүхээс гадна хоёр дасгалжуулагчийн тулаан ч бас сонирхолтой. Моуриньо "Интер"-ийг удирдаж байхдаа Аваргуудын лигийн F хэсэгт Пепийн удирдсан "Барселона"-тай хамт багтсан. 2009-2010 оны улиралд "Интер" түрүүлсэн жилээ "Барса"-тай дөрөв тулсан нь энэ. 2009 есдүгээр сард "Интер" талбайдаа "Барса"-тай үзэж, 0:0-ээр тэнцсэн билээ. "Барселона" илт давуу байж, зогсоо зайгүй дайрсан ч "Интер"-ийн хамгаалалтыг давж гараагүй. Харин 2009 оны арваннэгдүгээр сард "Барселона" талбайдаа "Интер"-ийг хүлээж авч, 2:0-ээр буулгаж авсан. Херард Пике болон Педро нарын гоолоор Пеп агуу

дасгалжуулагчдын тулааны эхний ялалтаа авсан юм. Мөн хоёр баг хэсэгээс 1, 2-оор гарч, тэмцээнээ үргэлжлүүлсэн. "Интер" шөвгийн 16-д "Челси"-г, шөвгийн наймд "ЦСКА"-г мултгалж, хагас шигшээд шалгарсан. Харин "Барса" хасагдах шатны эхний учраас "Штутгарт"-ыг мултгалж, шөвгийн наймд "Арсенал"-ыг буулгаж авснаар шөвгийн дөрөвт орж ирсэн. Хагас шигшээн эхний тоглолт 2010 оны дөрөвдүгээр сард "Интер"-ийн талбайд болоход Милан хотын баг "Барселона"-г 3:1-ээр буулгаж авч, Моуриньо эхний ялалтаа байгуулсан. Улмаар долоо хоногийн дараа хариу тоглолт болох "Барса" 1:0-ээр хожсон ч хоёр тоглолтын нийлбэр дүнгээр "Интер" финалд үлдэж чадсан билээ. Улмаар финалд "Байерн"-ыг 2:0-ээр хожиж, аваргуудын лигт түрүүлж байлаа. Харин Пеп болон Моуриньогийн хожлын

харьцаа 2:1 болж, Испани эрхэм давамгайлж эхэлсэн юм. "Интер"-тэй хамт аваргуудын лигт түрүүлсэн Моуриньо тэр жилдээ уналтад орчихоод байсан алдарт "Реал Мадрид"-ыг босгох даалгавартайгаар Испанид ирсэн. Ингэснээр Пеп болон Моуриньогийн тулаан "Эль классико"-д өрнөх нь тодорхой болов. 2010 оны арваннэгдүгээр сард ла лигийн хүрээнд "Барселона" талбайдаа "Реал"-ыг хүлээж авч, 5:0-ээр бутниргэж, хөлбөмбөгийн түүхэн дэх нэгэн агуу ялалтыг байгуулж байсан билээ. Моуриньо "Реал"-ыг удирдсан анхны тоглолдооийнхүү Пепийн багт арчуулсан юм. Харин 2011 оны дөрөвдүгээр сард "Реал" талбайдаа "Барса"-г хүлээж авч, 1:1-ээр тэнцэв. Гэхдээ Пеп болон Моуриньогийн ялалт, ялагдлын харьцаа 3:1 болчихоод байлаа. Энэ тоглолтын дараахан хоёр баг Эзэн хааны цомын тэмцээнд учраа таарахад Моуриньо өрсөлдөгч багийнхаа

Бушкашын академид суралцах хүүхдүүдийг өнөөдөр үднэ

Монголын Хөлбөмбөгийн холбоо өсвөр, идэрчүүдийн шилдэг тоглогчдоо Унгарын алдарт Бушкаш академид жилийн хугацаатай, үнэ төлбөргүйгээр суралцуулах болжээ. Тус академид суралцах дөрвөн хүүхдийг тодруулах сонгон шалгаруулалт 15, 16, 17, 19 хүртэлх дөрвөн насны ангилалын дагуу өнгөрсөн сард явагдсан. Шалгаруулалтын дүн

гарахад "Харацай" багийн Б.Амгаланбаг /U15/ дээд лигийн "Хоромхон"-ы гарааны тоглогч Г.Ганбаяр (U-16), "Улаанбаатар" клубын О.Хантэнгэр (U17), Нэгдүгээр лигийн "Бешикташ" багт тоглодог Д.Тэмүүлэн (19) нар ховорхон тохиох боломжийн эзэд болсон байна. Эдгээр тоглогчид бүгд өөрсдийн насандаа шилдэгт тооцогддог төдийгүй бага залуу насандаа

дээд лигийн тэмцээнд өрсөлдсөн авьяаслаг тамирчид юм. Хилийн чандад суралцахаар болсон хөвгүүд маань зорьсон газартаа сайн суралцах юм бол Испаний алдарт "Реал Мадрид"-ын академируу ч шилжих боломжтой юм байна. Тэгвэл Унгарт хөлбөмбөгийн академид суралцахаар шалгарсан тамирчдыг үдэх ёслол өнөөдөр 12:00 цагт МХБХ-ны байранд болох юм.

Гризманны төлөө "Челси" болон Манчестер Юнайтед" өрсөлдөх нь

Испанийн "Атлетико Мадрид" клубын довтлогч Антуан Гризманны төлөө "Челси" болон "Манчестер Юнайтед" клубүүд өрсөлдөж эхэлсэн талаар The Telegraph мэдээлжээ. "Челси"-гийн хувьд сүүлийн хоёр жил "Атлетико" руу хараа

бэлчээж, Гризманныг авах аятайхан боломжийг хүлээж байгаа аж. Тэгвэл Жозе Моуриньо Франц довтлогчийг солилцоо наймааны түүхэн дэх хамгийн өндөр үнээр авахад бэлэн байгаа талаар мэдээлэл гарч байсан билээ. Тиймээс

ирэх өвлийн солилцоо наймааны цонхоор Английн хоёр том баг Гризманны төлөө ширүүхэн өрсөлдөх бололтой. Эсвэл ирэх зуны солилцооны цонхоор түүний үнэ 100 саяыг хол давж магадгүй байна.



ДАВИД ЛУИЗ:
Конте намайг хаана тогло гэнэ, би тэнд нь тоглоно

дөрөвдүгээр тойрогт "Соусси" клубын талбайд зочлон тоглоно. Харин Луиз энэ тоглолтод оролцохоор бэлтгэлээ базааг байгаа бөгөөд Контегийн тогло гэсэн байрлалд хаана ч байсан тоглоно хэмээн ярьжээ. Тэр нь хамгаалалтын болон хагас хамгаалалтын байрлал байх нь хамаагүй аж. Тэрбээр "Би тоглож л байвал хаана ч хамаагүй. Би багтаа туслахыг л хүсч байна" хэмээн клубын албан ёсны сайтад ярьжээ. Мөн тэрбээр "Конте намайг хаана тоглуулахыг хүсч байна, би тэнд. Би аль ч байрлалд тоглоход бэлэн байна. Бид премьер лигт түрүүлэх цаг болсон. Тэр нь энэ улиралд гэдэгт найдаж байгаа. Би үүний төлөө шаргуу хөдөлмөрлөнө. Бидний зорилго бол премьер лигт түрүүлэх" хэмээн нэмж ярьсан байна.

СПОРТ

Улаанбаатарт:

Маргааш
 Өдөр +19
 Шөнө +7

Нөгөөдөр
 Өдөр +19
 Шөнө +7



Аргын тооллын:
 2016 оны 09-р сарын 09,
 Баасан гараг

Билгийн тооллын:
 Натрын дунд улаагчин
 тахиа сарын шинийн 8.
 Долоон улаан лэнэгтэй Хөх
 торь өдөр. Сугар гараг

Наран ургах/шингэх:
 07:25 / 19:19

Үс засуулбал:
 Нас уртасна.



Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, гарагийг тахиx, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртасна.

ДЭЛХИЙН БӨХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ХУРЛААР МОНГОЛЫН АСУУДЛЫГ ЯРЬСАНГҮЙ

Франц улсын Маконь хотод болсон залуучуудын ДАШТ-ний сүүлийн өдөр WWW, Дэлхийн бөхийн нэгдсэн холбооны хоёр жил тутам болдог ээлжит Их хурал боллоо. Дэлхийн өнцөг булан бүрээс цугларсан үндэсний холбоодын төлөөлөгчид Их хурлаар бөхийн спортын хөгжүүлэх асуудлыг хамтран хэлэлцэж сонирхсон тодорхой асуудлуудаар санал хурааж Товчоо гэж нэрлэгддэг тус холбооны Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгодог ажээ. ДБНХ-ны ерөнхийлөгч Н.Лалович, ерөнхий нарийн бичгийн дарга Мишель Дюссон нар 120 гаруй улсаас ирсэн төлөөлөгчдийн өмнө тус холбооноос өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хийсэн үйл ажиллагааны амжилтыг болон санхүүгийн тайланг танилцуулж хэлэлцүүлсэн байна. Ерөнхийлөгч Н.Лалович тавьсан илтгэлдээ, бөхийн тэмцээнийг жин бүрийг хоёр өдөр дараалан жин үзүүлэлтэйгээр хоёр өдөрт багтаан явуулж байх тухай асуудлыг дэвшүүлжээ. Учир нь ингэснээр нь алтан медаль авахын төлөө өрсөлдөөнийг илүү сонирхолтой болгож, бөхчүүдийг жин хасах эрүүл бус үзэгдлээс ангид байх бололцоо олгоно гэж онцлон дурдсан байна. Гэвч их хурлаар дээрх асуудлаар тодорхой шийдвэр гаргаагүй боловч “Токио-2020” олимпын наадам гэхэд өөрчлөлтүүдэд дассан байхын тулд аливаа өөрчлөлт, засварыг шуурхай хийж байх нь зүйтэй” гэж ерөнхийлөгч Н.Лалович хэлжээ. Мөн зуны олимпын “Рио-2016” наадамтай холбоотой гарсан



маргаантай асуудалд Их хурал анхаарал хандуулж, шүүгчдийн сургалтад зориулсан шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

саналыг сайшааж, ОУОХ-ны Ёс зүйн дүрмийг дэмжиж шүүгчдийн асуудлыг тус холбооны Спортын газрын мэдэлд шилжүүлсэн байна.

Түүнээс гадна их хурлаар тивийн аварга шалгаруулах тэмцээний хураамжийн асуудлыг хэлэлцэж одоо байгаа хураамжийн хэмжээг 15-20 хувиар

нэмэгдүүлэх шийдэлд хүрч ДАШТ-нийг зохион байгуулах эрхийн хураамжийг санал болгосон хэмжээнд үлдээсэн байна. Тэгвэл 2018 онд болох Их хурлаар тодорхой бус байгаа насанд хүрэгчдийн ДАШТ болох орныг шалгаруулахаар тогтжээ. Хамгийн гол нь энэ хурлаар Монголын чөлөөт бөхийн баг тамирчдыг Олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцохыг хориглосон асуудлаар огт яриагүй ажээ. Монголчуудын хамгийн их хүлээж байсан асуудал энэ байсан ч Дэлхийн бөхийн нэгдсэн холбоо хуралдахаа огт дурьдсангүй.

Пеле, Зико нар Монголд ирж магадгүй

Н.БОЛЦ

Монголын Хөлбөмбөгийн холбоо, Бразилийн Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллаж, Латин Америкийн хөлбөмбөгийн хэв маягийг эх орондоо нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхэллээ. Дэлхийн хамгийн чадварлаг, авьяаслаг хөлбөмбөгчдийн уурхай болсон Бразил улсын хөлбөмбөгийн холбоотой хамтран, олон ажил хийхээр төлөвлөөд байгаа аж. МХБХ эхний ээлжинд Бразилийн Парана мужын “Паранэнс” багтай хамтран ажиллахаар болсон байна. Тиймээс тус багтай “Үндэсний Дээд Лиг” болон “1-р лиг”-ийн багууд хамтрах үүд хаалга нээгджээ. Энэ ажлыг хэрэгжихэд Монгол Улсаас Бразил Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ч.Сосормаа идэвх зүтгэл гарган ажилласан юм байна. Мөн хамтын ажиллагааны хүрээнд Бразилын алдарт хөлбөмбөгчдийг эх орондоо айлчлуулахаар холбоо тогтоогоод байгаа ажээ. Тэр дунд Пеле, Зико гэх мэт дэлхийн шилдэг хөлбөмбөгчдийн нэр дурьдагдаж байгаа юм байна.

Б.Гангаамаа арг түмнээсээ тусламж хүслээ

Дэлхийн зулай Эверестийн оргилд хөл тавьсан Монголын анхны эмэгтэй уулчин, Монгол Улсын гавьяат тамирчин, уулын спортын ОУХМ Б.Гангаамаа Антарктид тивийн ноён оргил болох 4897 метр өндөр Винсон Массифид гарахаар төлөвлөж байгаа ажээ. Тэрбээр үүнээс бусад буюу дэлхийн хамгийн өндөр зургаан ноён оргилд гарч, эх орныхоо далбааг мандуулсан гайхамшигтай уулчин юм. Тэрбээр энэхүү оргилд гарахын тулд ард түмнээсээ хандив гуйж байгаа юм. Б.Гангаамаа өөрийн фэйсбүүк хуудсаараа дамжуулж “Тамирчин хүний хүсэл мөрөөдөл тив дэлхий, Олимп байдагтай нэгэн адил уулчин хүний хүсэл мөрөөдөл, зорилгын нэг бол Дэлхийн долоон тив /7 summit/-ийн ноён оргил байдаг. Одоо Монголчууд бидэнд ганцхан том харайх үлдсэн. Дээрх авиралтууд нь ивээн тэтгэгдэг, хамтран ажилладаг, тусалж дэмждэг хувь хүн, байгууллагуудын тусламж, дэмжлэг болон миний 25 жилийн хөдөлмөрийн үр дүнгээр санхүүжигдэж, амжилттай явагдаж ирсэн. Тиймээс уулын спортыг ойлгон дэмжиж ирсэн тэдгээр бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэн мэхийн хүндэтгэе. Нүүр номоор надтай холбоотой байж, үзэгчгүй спорт хэмээх уулын спортын минь үзэгч дэмжигч байж ирсэн та бүхнээсээ дээрх авиралтад шаардагдах

зардлыг минь хуваалцаач хэмээн хүсч байна. Авиралтад нийт 42 мянган ам.доллар шаардагдах бөгөөд найз нэг бүр маань таван ам.доллар буюу 10.000 төгрөг тодрог хандивлахагт нийт зардлын маань 50 хувь нь бүрдэх юм. Авиралтын эхлэх хугацаа арванхоёрдугаар сарын 15-наас бөгөөд олон улсын авиралтын журмын дагуу авиралт эхлэхээс 90 хоногийн өмнө мэдүүлгээ өгч, төлбөрийн 50 хувийн баталгаажилтаа хийж эрхээ авсан байх ёстой. Бидэнд хагас сарын хугацаа үлдээд байна аа. Та бүхний оруулсан хувь нэмэр энэ амжилтын түүх болон номонд үлдэж, эх орны маань нэр дэлхийн уулын спортод тодоор бичигдэхэд үнэтэй хувь нэмэр болох юм” гэв.

Та бүхэн уулчин Б.Гангаамаагийн хүсэл мөрөөдлийг биелүүлж долоо дахь ноён оргилоо эзлэхэд нь хандив өргөхийг хүсвэл:

ХАНДИВЫН ДАНС:
ХААН Банк Худалдаа Хөгжлийн Банк
 Төгрөг: 509 063 3576
 Төгрөг: 495 058 495
 Доллар: 495 058 554
 Email: gangaamaa8848@gmail.com
gangaamaa128@yahoo.com
 Page Facebook: [Gangaamaa Badamgarav](https://www.facebook.com/GangaamaaBadamgarav)
 Mobile: 976-9900 4444 өөртэй нь холбогдоорой.

Бодибилдингчид Азийн аваргаас хоёр алтан медальтай ирлээ



Бодибилдинг, фитнесийн Азийн аварга шалгаруулах тэмцээн Бутан улсад энэ сарын 5-8-ны өдрүүдэд болж, шилдгүүдээ тодрууллаа. 50 дахь удаагийн тус тэмцээнд манай улсаас эх орноо төлөөлөн 10 тамирчин оролцож, зургаан медаль хүртээд ирлээ. Тухайлбал, дэлхийн аварга Г.Угалзцэцэг, ДАШТ-ий хүрэл медальт Г.Гансаруул нар алт, А.Ичинноров, Б.Гэрэлцэцэг, Д.Мөнх-Эрдэнэ нар мөнгө, Н.Түвшинбаяр хүрэл медаль тус тус хүртсэн юм. Ингэснээр манай эмэгтэй тамирчид хоёр алт, хоёр мөнгөн медаль авсан амжилтаар багийн дүнгээр дэд байрт шалгарчээ.

Аадар багын айд Цэнгэлийнхээ дуулиагаар Дарханхогьт зорино. Гэвч тэнд Пантуг гэх түүний сөрөгтэй найз нь эцгийнх нь сэтгэлтэй хуйвалдан урхи бэлдсэн байв. Аадарын эцэг хазгар Чука Мандал нарт эргэний тооцоо байсныг Пантуг сөрөг ашигтайгаар эргүүлж найзгаа золиослож орхино. Пантугын балгаар хайртай бүсгүй дөнгөж мөчлөсөн бяцхан охиноосоо хагацсан Аадар ч бас ор сураггүй алга болно. Зургаан жилийн дараа гэнэт гарч ирсэн Аадар чухамноу хийж хэрхэх бол? Тэр амьдралаа эргүүлэн авч чадах болов уу?

Еврейн нөлөөтэйгэр бүлээс гаралтай Бен-Хур-аас ромын иргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Өргөж эх орондоо ирээд өшөөгөө авна.

Хэн мэдэх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ. Уул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэргийн хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно. Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлснгүй тас нуужээ..